# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
# ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 01 өдөр Дугаар 33 Шарга

## Нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 , Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2015 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу үр дүнтэй захиран зарцуулж хэрэгжилт, үр дүнг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга /Э.Эрдэнэцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АЗБАЯР

D:/Togtool 2015/

09 01

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 01-ний
31 дугаар тогтоолын Хавсралт

**2015 ОНЫ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Хийгдэх ажил | Зардал /мян.төг/ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Сумын байгаль орчны бодлогыг тодорхойлох нээлттэй хэлэлцүүлэг, зөвлөгөөн | 1675,9 | Батлагдсан төсвөөс 368,0 төгрөгийг хасч тодотгосон |
| 2 | Гадаргын усны тоо бүртгэлийн ажил хийх | 90,6 | Батлагдсан төсвөөс 180,0 төгрөгийг хасч тодотгосон |
| 3 | Дэлгэр мөрөн голын сав газрын загас агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах | 400,0 | Батлагдсан төсвөөс 252,0 төгрөгийг хасч тодотгосон. |
| 4 | Идэвхитэн байгаль хамгаалагчийн ажиллах нөхцлийг сайжруулах, идэвхижүүлэх | 800,0 | Дээрхи хөтөлбөр үйл ажиллагаанаас тодотгосон 800,0 төгрөгийг идэвхитэн байгаль хамгаалагчийг идэвхижүүлэх урамшуулалд зарцуулахаар төлөвлөгөөнд нэмэлт оруулав. |
| | **Дүн** | **2966,5** | |